

УЦУОШТӨВ-Н ДАРГА
2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр



АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар "Ус Цаг Уур Орчны Шинжилгээний Төв"-ийн сул, эзгүй орон тоог нөхөх ажилтан сонгон шалгаруулах, мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Ажилтан сонгон шалгаруулахад Монгол Улсын үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, УЦУОХШ-ний тухай хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох бусад хууль тогтоомж эрх зүйн актуудыг үндэслэл болгоно.

Хоёр. Сонгон шалгаруулалтанд оролцогчдын бүрдүүлэх материал

2.1 Сул, эзгүй орон тооны зарыг www.khovd.namem.gov.mn сайтаар зарлана.

2.2 Ажилд орохыг хүссэн иргэн дараах баримт бичгийг бүрдүүлнэ.

- 2.2.1 Төрийн албан хаагчийн анкет
- 2.2.2 Ажилд орохыг хүссэн өргөдөл
- 2.2.3 Хөдөлмөрийн болон Нийгмийн даатгалын дэвтэр;/ажил эрхэлж байсан бол/
- 2.2.3 Иргэний үнэмлэхний хуулбар;
- 2.2.4 Мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбар

Гурав. Сонгон шалгаруулалтанд оролцогчдын материалыг хүлээн авах

3.1 УЦУОШТөвөөс зарласан ажлын байранд заагдсан материалыг зар олон нийтэд зарлагдсан өдрөөс ажлын 10 хоногийн дотор хүлээн авна.

3.2 3.1-д заасан хугацаа хэтэрсэн тохиолдолд материалыг хүлээн авахгүй

3.3 Шаардлага хангаагүй материалыг оролцогчид буцаан олгож цаашдын сонгон шалгаруулалтад оролцуулахгүй.

Дөрөв. Сонгон шалгаруулалтын зохион байгуулалт

4.1 Сонгон шалгаруулалт нь ярилцлага болон мэдлэг, ур чадвар сорилтын гэсэн 2 үе шаттай байх бөгөөд даргын зөвлөл зохион байгуулна. /Мэргэжлийн инженерийн орон тоон дээр/

4.2 УЦУОШТ-н харъяа өртөө харуулуудад сонгон шалгаруулалт нь хэрэв мэргэжлийн бус хүн оролцох бол төв дээр тусгай хөтөлбөрийн дагуу 21 хоногийн сургалтад хамруулж шалгалтыг тест болон аман хэлбэрээр авна.

4.3 Мэдлэг, ур чадварын сорилтын асуулгыг тухайн сонгон шалгаруулах албан тушаалын дагуух мэргэжлийн албан хаагчаас санал авч даргын дэргэдэх зөвлөл нэгтгэн боловсруулан даргаар батлуулна.

Тав. Сонгон шалгаруулалтыг дүгнэх

5.1 Сонгон шалгаруулалтад тэнцэн, өндөр оноо авч, эхний 2 байранд тэнцсэн ажил горилогчдыг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, шийдвэр гаргана.

УЦУОШТӨВИЙН ЧАНАРЫН ДОТООД ХЯНАЛТЫН КОМИСС